

МӨНГӨ ХҮҮЛЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 35 жил болж байгаа хэдий ч зээлийн хүү бодитойгоор буурч, олон улсын жишигт нийцсэн нэг оронтой түвшинд хүрч чадаагүй бөгөөд арилжааны банкуудын нийтэд зарлаж буй зээлийн хүү дунджаар 17-18 хувь, шимтгэл болон бусад зайлшгүй зардлыг тооцсон бодит өртөг нь 18-19 хувьд хүрч байгаа нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дарамтыг нэмэгдүүлж, бодит эдийн засгийн өсөлтийг сааруулж байна.

Монгол Улсад зээлийн хүүгийн түвшинг бууруулах зорилгоор өнгөрсөн хугацаанд хэд хэдэн бодлогын баримт бичиг, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байв. Тухайлбал, “Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх хөтөлбөр” 2011 онд баталж байсан бол 2014 онд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталсан.

Монголбанкнаас баримталж ирсэн бодлого, чиглэл нь зээлийн хүүг захиргааны аргаар тогтоох бус, харин эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар зах зээлийн зарчмаар бууруулах нь илүү үр дүнтэй гэж үздэг. Учир нь захиргаадалтын арга нь зах зээлийн үйл ажиллагаанд гажуудал үүсгэх эрсдэлтэй бөгөөд дунд, урт хугацаанд тогтвортой хэрэгжих боломж хязгаарлагдмал байдаг.

Улмаар “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” баримт бичгийн төслийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци хамтран боловсруулан, баталсан. Энэхүү стратеги нь зах зээлийн зарчимд тулгуурласан, макро эдийн засгийн орчныг сайжруулах, бодлогын хүүгийн дамжих сувгийг идэвхжүүлэх, банкны эрсдэл даах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах замаар зээлийн хүүгийн түвшинг тогтвортой бууруулах зорилготой байв. Уг стратеги нь өмнөх хөтөлбөрүүдийн алдаа дутагдлыг засах, илүү системтэй, уялдаа холбоотой бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд зээлийн хүүгийн бууралтад нөлөөлөх макро болон микро түвшний хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх шаардлагатайг онцолсон.

Монгол Улсын хувьд 2024 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагын зээлийн жилийн жигнэсэн дундаж хүү 42 хувь, арилжааны банкны зээлийн жилийн жигнэсэн дундаж хүү 18 хувь, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн зээлийн хүүгийн дээд хязгаар нь 54 хувьтай байна. Түүнчлэн сүүлийн 10 жилийн хугацаанд зээлийн хүүгийн хэмжээ санхүүгийн салбарт дорвитой буураагүй байна.

Зах зээлийн эдийн засгийн онолоор зээлийн нийлүүлэлт нэмэгдэхийн хэрээр зээлийн хүү буурах ёстой боловч Монгол Улсад энэ зүй тогтол үйлчлэхгүй байгааг сүүлийн 18 жилийн бодит статистик тоо баримт тодорхой харуулж байна. Тухайлбал, 2017–2025 оны хооронд зээлийн үлдэгдэл 13.6 их наяд төгрөгөөс 41.5 их наяд төгрөг болж бараг гурав дахин өссөн боловч Монголбанкнаас тооцдог зээлийн жигнэсэн дундаж хүү 18.8 хувиас 17.36 хувь болж, ердөө 2.54 нэгж хувиар буурсан бөгөөд сүүлийн найман жилийн хугацаанд харин 0.36 нэгж хувиар өссөн байна.

Монгол Улсад зээлийн хүүгийн зохицуулалтын хувьд Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.1-д “Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно.” 452.3-д “Зээлдүүлэгч зээлийн хүүгийнхээ хэмжээг нийтэд мэдээлэх үүрэгтэй.”, 453.1-д “Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй.” гэж заасан. Энд зээлийн хүүг ямар хэмжээнд байх талаар хууль эрхзүйн ямарч үндэслэл, заалт байхгүй байгааг харж болно. Өөрөөр хэлбэл зээлдүүлэгчийн үзэмжээр зээлийн хүүг тогтоох, цаашлаад мөнгө хүүлэх хуулийн цоорхой байгааг харж болохоор байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5.1.1-д “зээл” гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр хүүтэй буюу хүүгүй бусад этгээдэд аливаа хэлбэрээр олгосон мөнгөн хөрөнгийг” гэж 5.1.6-д “хүү” гэж гэрээний үндсэн дээр мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөр буюу үнийг” гэж тус тус заасан мөртөө хүүгийн хэмжээний тухай заалт, үндэслэл мөн дутаж буйг анзаарч болно.

Мөн хуулийн 213-т “Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.” гэж заасны дагуу Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А-106/298 дугаар хамтарсан тушаалаар “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг баталсан нь бусад зээл олгогч нарт хүү тогтоох ямар нэгэн хууль эрхзүйн үндэслэл дутаж байгааг харуулж байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлд “Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина”, мөн “Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдээс тогтоосон бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг бууруулахыг санал болгох, саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох бөгөөд энэтухайгаа нийтэд мэдээлэх эрхтэй байна” гэж заасны дагуу зохицуулалтын байгууллагаас зөвхөн шимтгэл, хураамжид хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалттай байна.

Монгол Улсын хууль тогтоомжид зээлийн хүү ямар дээд хэмжээнд байх талаар тодорхой заалт огт байхгүй, зөвхөн зээл хүүтэй буюу хүүгүй байж болох, хүүгийн хэмжээг нийтэд мэдээлэх үүрэгтэй гэсэн ерөнхий зохицуулалт л тусгагдсан бөгөөд хүү тооцох аргачлалыг батлах тухай заалт нь хүүгийн дээд хязгаар тогтоосон гэсэн утгыг илэрхийлэхгүй байна.

Үүний үр дүнд зээлийн хүүгийн хэмжээ бараг бүхэлдээ зээлдүүлэгчийн үзэмжид үлдэж, мөнгө хүүлэхтэй төстэй нөхцөл байдал үүсэх эрх зүйн орон зай нээлттэй хэвээр байгаа бөгөөд нөгөө талд өрсөлдөөн сул, олигополь бүтэцтэй зах зээл дээр зах зээлийн жамаар хүү буурна гэж хүлээх боломж үндсэндээ үгүй болж байна.

Иймээс Монгол Улсад зээлийн хүү өндөр хэвээр хадгалагдаж буй гол шалтгаан нь нэг талаас зээлийн хүүгийн дээд хязгаар, шалгуурыг тогтоосон хууль эрх зүйн

үндэслэл дутмаг, нөгөө талаас зээлийн зах зээл цөөн оролцогчийн давамгайлсан олигополь бүтэцтэй байгаатай холбоотой бөгөөд эдгээр нөхцөлд төрөөс зээлийн хүүгийн зохистой дээд хязгаар тогтоох, шаталсан зохицуулалт хийх нь эдийн засгийн хувьд логиктой, хууль зүйн хувьд үндэслэлтэй, зайлшгүй шаардлагатай арга хэмжээ гэж дүгнэж байна.

ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Зээлийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний байдал

Монгол Улсын зээлийн зах зээлд Херфиндаль-Хиршманы индекс (НИ) 2000-аас давж, зах зээлийн өндөр төвлөрөл тогтсоныг илэрхийлж байгаа бөгөөд 2025 оны байдлаар ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк нь төгрөгийн зээлийн ойролцоогоор 80 хувийг эзэлж байна. Олон улсын үнэлгээний аргачлалаар 50–80 хувийн төвлөрөлтэй зах зээлийг олигополь, 80 хувиас дээш төвлөрөлтэйг монополь руу шилжиж буй зах зээл гэж үздэг. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас ХААН банкиг зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгж гэж тогтоосон нь зээлийн зах зээлд бодит өрсөлдөөн алдагдсаныг албан ёсоор баталгаажуулж байна.

Зээлийн хүүгийн бодит түвшин

Монголбанк зээлийн хүүг жигнэсэн дундаж аргаар тооцож байгаа нь бодит нөхцөл байдлыг бүрэн илэрхийлэхгүй байна. Учир нь ипотекийн зээл, Засгийн газар болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлүүд нийт дундажид хамрагдсанаар бодит зах зээлийн зээлийн өртөг хийсвэрээр буурч харагдаж байна.

Бодит байдалд бичил бизнес, жижиг, дунд үйлдвэр, хэрэглээний зээлийн дундаж хүү 20-22 хувь, зарим төрлийн зээл (автомашин, богино хугацаат хэрэглээний зээл) 30-35 хувьд хүрч байгаа бөгөөд банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүү 30-40 хувь, ломбард болон өдрийн зээлийн хүү нь илт мөлжлөгийн шинжтэй байна.

ЗЭЭЛИЙН ХҮҮ ӨНДӨР БАЙГААГИЙН ГОЛ ШАЛТГААН

Зээлийн хүү өндөр хэвээр байгаагийн гол шалтгаан нь нэгдүгээрт, хадгаламж зээлийн маржин Монгол Улсад 5-7 хувьтай байгаа нь дэлхийн дундаж 4-6 хувиас өндөр; хоёрдугаарт, хадгаламжийн хүү инфляцийн түвшнээс тогтмол давж, 2025 онд инфляц 7.5 хувьтай байхад хадгаламжийн хүү 10-15 хувь хэвээр байгаа; гуравдугаарт, банкуудын ашигт ажиллагаа аж ахуйн нэгжийн аргаар тооцоход 80-150 хувьд хүрч байгаа явдал юм.

Эдгээр үзүүлэлт нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд мөнгө хүүлэлтийн шинжтэй, олигополь тогтолцоо бүрэлдсэнийг харуулж байна.

ДЭЛХИЙН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Дэлхийн 76 улс зээлийн хүүгийн дээд хязгаарыг хуульчилсан байдаг бөгөөд Япон улсад 20 хувь, Франц улсад 5.7-21.6 хувь, АНУ-д муж бүрт 12-17 хувь, Польш

улсад 20 хувь, Нидерланд улсад 15 хувиар тус тус тогтоосон байна. Эдгээр улс оронд зээлийн хүүгийн дээд хязгаарыг парламент, төв банк эсхүл засгийн газар тогтоож, тодорхой давтамжаар шинэчилдэг бөгөөд зээлдэгчийг шударга бус хүүгээс хамгаалах тусгай институц ажилладаг. Судалгааны дүнгээр зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоосон орнуудын дийлэнхэд зээлийн хүртээмж урт хугацаанд буураагүй, харин хэрэглэгчийн эрх, хамгаалалт бодитоор сайжирсан байна.

ХОЁР. Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн зорилго

Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн зорилго нь банк болон банк бус зээлдүүлэгчийн олгож буй зээлийн нийт бодит хүү (Annual Percentage Rate)-гийн дээд хязгаарыг хуульчлан тогтоох, мөнгө хүүлэлтийн шинжтэй бусад зээлийн үйл ажиллагааг хориглон таслан зогсоох, зээлдэгчийг хэт өндөр хүү, далд шимтгэл, шударга бус гэрээний нөхцөлөөс хамгаалах, зээлийн зах зээл дэх шударга өрсөлдөөн, ил тод байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, улмаар иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн дарамтыг бууруулж, бодит эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн ерөнхий бүтэц

Хуулийн төсөл нь эрх зүйн зохицуулалтын логик дараалал, хэрэгжилтийн уялдааг хангах үүднээс дараах таван бүлгээс бүрдэнэ. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт хуулийн зорилго, хууль тогтоомжийн тогтолцоо, хуулийн үйлчлэх хүрээ, мөн хуулийг хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж, зээлийн нийт бодит хүү (Зээлийн гэрээний нийт бодит хүү буюу APR-Annual Percentage Rate гэдэг нь зээлдэгч тухайн зээлийг авах, ашиглах, эргэн төлөхтэй холбоотой бүх зардлыг нэгтгэн тооцож, жилийн хувиар илэрхийлсэн бодит өртөг юм), мөнгө хүүлэлт, илүүдэл хүүгийн орлого зэрэг суурь ойлголтыг хуульчлан тодорхойлно.

Хоёрдугаар бүлэг. Зээлийн нийт бодит хүүгийн хязгаар

Энэ бүлэгт зээлийн төрөл тус бүрээр зээлийн нийт бодит хүүгийн дээд хязгаарыг тогтоох, уг хязгаарыг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулах, зээлийн нийт бодит хүүг тооцох, зээлдэгчид ил тод мэдээлэх журам, шаардлагыг тогтооно.

Гуравдугаар бүлэг. Хориглох үйл ажиллагаа

Энэ бүлэгт хуульд заасан дээд хязгаараас давсан хүү тогтоох, далд болон нэр өөрчилсөн шимтгэл, хураамжаар бодит хүүг нэмэгдүүлэх, зээлийн хүү, шимтгэлийг урьдчилан суутгах, давхар болон нууц гэрээ байгуулах, зээлийн бодит өртөгт хамаарах төлбөрийг нуух зэрэг мөнгө хүүлэлтийн шинжтэй үйл ажиллагааг хориглох зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэг. Хяналт, хариуцлага

Энэ бүлэгт хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэх эрх, үүргийг тодорхойлж, хууль зөрчсөн тохиолдолд илүүдэл хүүг хүчингүй болгох, зээлдэгчид буцаан олгох, санхүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх, давтан болон ноцтой зөрчил гаргасан этгээдийн

тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг хариуцлагын механизмыг тогтооно.

Тавдугаар бүлэг. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ бүлэгт хуулийг дагаж мөрдөх шилжилтийн хугацаа, хэрэгжилттэй холбогдон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос батлах журам, зааврын талаар зохицуулна.

Хуулиар зохицуулах харилцаа

Энэхүү хуулиар дараах үндсэн харилцааг зохицуулна. Үүнд:

1. банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, ломбард болон бусад зээлдүүлэгчийн:
 - зээлийн нийт бодит хүү тогтоох,
 - шимтгэл, үйлчилгээний төлбөр авах,
 - зээлийн гэрээ байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа;
2. зээлдэгчийн:
 - зээлийн бодит өртгийн талаарх бүрэн, үнэн зөв мэдээлэл авах,
 - шударга бус хүү, илүүдэл төлбөрөөс хамгаалуулах эрх;
3. хяналт хэрэгжүүлэгч байгууллагын:
 - хяналт шалгалт хийх,
 - зөрчил арилгуулах,
 - хууль зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох эрх зүйн харилцаа.

Хуулийн хамрах хүрээ

Энэхүү хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мөнгө зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй дараах этгээдэд хамаарна. Үүнд:

- банк;
- банк бус санхүүгийн байгууллага;
- хадгаламж зээлийн хоршоо;
- ломбард;
- мөнгө зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй бусад хуулийн этгээд.

Харин хувь хүн хоорондын арилжааны бус, ашиг олох зорилгогүй зээл, мөн хуульд тусгайлан өөрөөр зохицуулсан гадаадын зээл, тусламжийн хэлцэл нь энэ хуулийн хамрах хүрээнд хамаарахгүй.

Хуулийн үндсэн зарчим

Хуулийн төсөл нь дараах үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд:

- зээлийн бодит өртгийг бүрэн, ил тод мэдээлэх;
- мөнгө хүүлэлтийг захиргааны болон санхүүгийн хариуцлагын аргаар таслан зогсоох;
- олигополь бүтэцтэй зээлийн зах зээлд төрөөс зээлийн хүүг зохистой, хуульчлагдсан байдлаар хязгаарлах;
- зээлдэгчийг хамгаалах нь санхүүгийн тогтвортой байдлын суурь нөхцөл байна.

ГУРАВ. Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар:

Эдийн засгийн үр дагавар

Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль батлагдсанаар зээлийн зах зээл дэх нийт бодит хүүгийн дээд хязгаар хуульчлагдаж, банк болон банк бус зээлдүүлэгчдийн зээлийн хүү, шимтгэл, үйлчилгээний төлбөрөөр дамжуулан хэт өндөр ашиг хүртэх

боломж хязгаарлагдана. Үүний үр дүнд зээлийн бодит өртөг буурч, иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн ачаалал багасах нөхцөл бүрдэнэ.

Зээлийн өртөг буурснаар жижиг, дунд үйлдвэрлэл, боловсруулах салбар, хөдөө аж ахуй болон бодит эдийн засгийн салбаруудад чиглэсэн зээлийн эрэлт тогтвортой өсөх, бизнесийн ашигт ажиллагаа сайжрах, хөрөнгө оруулалтын идэвхжил нэмэгдэх эерэг нөлөө үзүүлнэ. Улмаар аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, татварын бааз тэлэх, улсын төсвийн орлого дунд болон урт хугацаанд өсөх боломж бүрдэнэ.

Нөгөө талаас, хуулийн хэрэгжилтийн эхний шатанд зээлдүүлэгчид эрсдэлээ дахин үнэлэх, зээлийн нөхцөлийг чангаруулах замаар зарим төрлийн зээлийн нийлүүлэлтийг богино хугацаанд хумих магадлал үүсч болзошгүй. Гэвч зээлийн хүүгийн дээд хязгаарыг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан уян хатан тогтоож, үе шаттай хэрэгжүүлэх зохицуулалт нь санхүүгийн зах зээлд огцом цочрол үүсэхээс сэргийлэх бодит боломжийг бүрдүүлнэ.

Нийгмийн үр дагавар

Хууль батлагдсанаар зээлдэгч иргэдийг хэт өндөр хүү, далд шимтгэл, шударга бус гэрээний нөхцлөөс хамгаалах эрх зүйн баталгаа бий болно. Өрхийн хэрэглээний болон цалингийн, тэтгэврийн, бичил зээлийн бодит өртөг буурснаар өрхийн санхүүгийн дарамт багасч, өрийн хэт ачааллаас үүдэлтэй нийгмийн эрсдэл, ядуурал гүнзгийрэх, санхүүгийн мөлжлөгт өртөх нөхцөл бодитойгоор буурна.

Мөнгө хүүлэлттэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэнээр хууль бус зээл, ломбардын мөлжлөгийн шинжтэй үйл ажиллагаа хумигдаж, санхүүгийн зах зээлд шударга ёсны зарчим бэхжинэ. Энэ нь иргэдийн санхүүгийн боловсрол, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлж, нийгмийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн, зээлийн шударга нөхцөл бүрдэх нь хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, бичил болон жижиг бизнесүүд тогтвортой үйл ажиллагаа явуулах, орлогын ялгаа гүнзгийрэхээс сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нийгмийн ач холбогдолтой.

Хууль зүйн үр дагавар

Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль батлагдсанаар Монгол Улсад мөнгө хүүлэлтийг тусгайлан тодорхойлж, зээлийн нийт бодит хүүгийн дээд хязгаарыг хуульчлан тогтоосон бие даасан эрх зүйн зохицуулалт бүрдэнэ. Ингэснээр одоогийн хууль тогтоомжид тодорхой бус, задгай орхигдож ирсэн зээлийн хүү, шимтгэлийн асуудал эрх зүйн хувьд нэг мөр ойлгомжтой болно.

Хууль хэрэгжсэнээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт хийх, зөрчил арилгуулах, илүүдэл хүүг хүчингүй болгох, санхүүгийн болон захиргааны хариуцлага ногдуулах бүрэн эрх тодорхой болж, хэрэгжилтийн үр нөлөө дээшилнэ. Мөн зээлдэгчийн эрхийг хамгаалах шүүхийн практикт тодорхой шалгуур, жишиг тогтож, иргэний маргааныг шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдана.

Үүний зэрэгцээ уг хууль нь Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжтой уялдан хэрэгжих бөгөөд зээлийн харилцаанд давхардал, хийдэл, зөрчил үүсэх эрсдэлийг бууруулах хууль зүйн орчныг бүрдүүлнэ.

Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль батлагдсанаар зээлийн зах зээлд эдийн засгийн хувьд тогтвортой, нийгмийн хувьд шударга, хууль зүйн хувьд тодорхой, хэрэгжих боломжтой зохицуулалт бүрдэж, иргэд, аж ахуйн нэгжийг санхүүгийн мөлжлөгөөс хамгаалах, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих суурь нөхцөл хангагдана.

ДӨРӨВ. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүгийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Монгол Улсын Үндсэн хуультай нийцэх байдал

Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн дараах суурь зарчим, заалттай бүрэн нийцнэ. Үүнд:

- Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нийгмийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлэх зарчим;
- 16 дугаар зүйлийн 3, 4 дэх заалтад заасан иргэний эдийн засгийн эрх, өмчлөх, шударга хөдөлмөр, санхүүгийн мөлжлөгөөс хамгаалуулах эрх;
- 19 дүгээр зүйлд заасан хүний эрх, эрх чөлөөг хууль тогтоомжийн хүрээнд хамгаалах төрийн үүрэг.

Хуулийн төсөл нь өмчлөх эрх, гэрээний эрх чөлөөг үндэслэлгүй хязгаарлахгүй бөгөөд зөвхөн олигополь зах зээлд үүссэн зах зээлийн бус, нийгмийн ашиг сонирхолд харш хэт өндөр хүүг хязгаарлаж буй зохистой зохицуулалт юм.

Бусад хууль тогтоомжтой уялдах байдал

Хуулийн төсөл нь дараах хууль тогтоомжтой уялдан хэрэгжинэ. Үүнд:

- Иргэний хууль (зээлийн гэрээ, хүү, гэрээний шударга нөхцөл);
- Төв банк (Монголбанк)-ны тухай хууль;
- Банкны тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль;
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль.

Эдгээр хуульд заасан зохицуулалтыг давхардуулахгүйгээр, нийт бодит хүүгийн дээд хязгаар, хяналт, хариуцлагын тусгай зохицуулалтыг энэхүү хуулиар шинээр тогтоож байгаа нь эрх зүйн тогтолцооны логик уялдааг хангана.

Цаашид шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай хууль

Хуулийн төслийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор дараах хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүснэ. Үүнд:

- Иргэний хуульд зээлийн гэрээний нийт бодит хүү (Зээлийн гэрээний нийт бодит хүү буюу APR-Annual Percentage Rate гэдэг нь зээлдэгч тухайн зээлийг авах, ашиглах, эргэн төлөхтэй холбоотой бүх зардлыг нэгтгэн тооцож, жилийн хувиар илэрхийлсэн бодит өртөг юм)-гийн ойлголт, илүүдэл хүүгийн эрх зүйн үр дагаврыг тодорхой болгох;
- Банкны тухай болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд зээлийн нийт бодит хүүгийн дээд хязгаарыг мөрдүүлэх, зөрчилд хариуцлага тооцох зохицуулалтыг уялдуулах;
- Зөрчлийн тухай хуульд мөнгө хүүлэлтийн шинжтэй зөрчилд хүлээлгэх захиргааны хариуцлагыг нарийвчлан тусгах.

Харин одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлага үүсэхгүй бөгөөд зөвхөн уялдаа холбоог хангах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.